

Профессор. Д.Содномгомбо
Улс төр судлалын тэнхимийн зөвлөх багш

Глобаль ертөнцийн тухай шинжлэх ухааны үүсэл, хөгжил, арга зүйн зарим асуудал

Хүн төрөлхтөн амиа хорлох эсвэл нэг гэр бүл
болон амьдрах хоёрын нэгийг л
сонгох болжээ. А.Тонби

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүллийн агуулга нь орчин үеийн глобаль асуудлын онолын үндэс, шинэчлэл, түүнийг судлах арга зүйн асуудлыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн авч үзэхийг зорьсонд оршино. Энд глобализмын онолын тодорхойлолт, түүний илэрч (ууй нийгмийн хүрээнүүдийн баримт, даяарчлалын онолын үндэс, байгаль нийгэмд илэрдэг онцлог, даяаршил ба даяарчлалын объектив, субъектив талууд онцлогийг харуулсан явдал нь өгүүллийн онцлог, шинэлэг тал оршино.

Түлхүүр үг: Глобализм, глобалчлал, дэлхийн глобаль асуудлууд тэдгээрийг даван туулах арга зам.

Илэрхий утга санаагаар ертөнц цаг ямагт “глобаль” байсан, хүн төрөлхтний түүх бол “даян дэлхийн түүх мөн” болохоор глобаль хөгжлийн үзэл санаа ертөнц гэсэн утгыг агуулж ирсэн байна. Гэвч шинжлэх ухааны биеэ даасан чиглэлийн хувьд глобализмын томъёолол сав саяхан өнгөрөгч зууны 60-70-аад оны зааг дээр үүсч, өргөн хэрэглэгдэх болжээ. Яагаад эртний дэлхийн үзэл санааг тусгасан энэ чиглэл хожимдож хэрэгжсэн юм бэ? Энэхүү асуултад хариулахыг оролдъё.

Хүн төрөлхтний хувь заяа, түүх нэгдмэлийн тухай үзэл санаа бүр эртний дэлхийн философид тов тодорхой өгүүлэгдэж байжээ. Гераклит ертөнцийг зүй тогтлоор асаж, зүй тогтлоор унтарч, өгсөх замаар: газар, ус агаар, гал уруудах замаар: гал, агаар, ус газар болон дэс дараалан хөгжиж байдаг нэгдмэл зүйл мөн гэж үзэж байжээ. Эртний Грекийн нэрт түүхч Полибий хойчийн хойч үеийнхэндээ түүхэн үйл явцын глобаль шинжийн тухай үлэмжхэн дэлгэрэнгүй төсөөллийг үлдээжээ. Тэрээр “түгээмэл түүх” гэдэг зохиолдоо нэг нэгнийгээ цувралаар халж солигч төрийн байгууламжийн хэлбэрүүд: эзэн хаант засаг-эзэрхэг засаг-язгууртны засаг-цөөхөн баячуудын эзэрхэг засаг-ардчилсан засаг-үймэлдсэн олны засгийн гайхамшигтай хөрөг зургийг дүрслэн харуулжээ.

Мөчлөг глобаль хөгжлийн тухай эртний дэлхийн үзэл санаа олон талаар эмгэнэлт шинжтэй юм. Хүний орон зай, цаг хугацаан дахь оршин тогтнол өөртөө түүнийг зайлшгүй мөхөлд хүргэх лай ланчгийг агуулж байна. Гарал үүсэл, аюул мөхлийн эмгэнэлт хүрээ бол глобаль хөгжлийн анхдагч хэлбэр мөн.¹ Гэхдээ тэрхүү эмгэнэл өөдрөг шинжтэй юм. Эртний дэлхийн сэтгэгчид байгальд болон төр улс дахь хүний амьдралын цог заль, сүр жавхланг онцлон тэмдэглэдэг байжээ.

Эмгэнэлт гутранги үзлийн халааг авсан шинэ үед ард түмнүүдийн нэгдмэл түүхэн хувь заяаг үзэх, амьдралыг бататгагч өөдрөг үзэл буй болжээ. Дидро, Даламбер, Вольтер, Кондерсе болон XVIII зууны бусад соён гэгээрүүлэгчид хүний дэвшлийн тухай, юуны өмнө хүний оюун ухааны дэвшлийн тухай бичиж байжээ. Дэвшилт глобаль хөгжлийн номлол оюун ухаан, шударга ёс, энх амгалан, буянт сэтгэлийн оргилд хүрэх хүн төрөлхтний зогсолт ба уналтгүй, хэлбэрэлтгүй дэвшлийг номлож, баталж байжээ. Соён гэгээрүүлэгчдийн үзэл гэнэхэн шинжтэй ч гэсэн тэд нар удаан хугацааны туршид

¹ Тиллих П.История и Царство Божие Философия истории. Антология. М. Аспект-Пресс, 1994. с-237-238./

сая сая хүмүүсийг түүхэн үйл хэрэгт сэргээж, зоригжуулсан билээ. Дэвшлийн чин хүслэнгээс дэвшилт итгэл үнэмшлийн аливаа эвдрэл бол оюуны сүйрэл мөн гэж үзэж итгэл алдардаг үй олон хүн амьдралын утга санааг олж авдаг байсан байна.

Гэтэл дэвшилт глобаль хөгжлийн үзэл санаа өнгөрсөн зууны туршлагаар хүчтэй гутаагджээ. Шинжлэх ухаан-техникийн хувьсгал урьд өмнө түүхэнд байгаагүй экологийн хямралыг дагуулан гаргасан юм. Энэ зуунд гарсан улс төрийн хувьсгалууд, дэлхийн дайнүүд нэгэнт болоод өнгөрсөн үзэгдэл мэт санагдаж болох боловч шударга хүн төрөлхтөнд үеийн үед мартагдашгүй гамшигт аллага хядлага, үхэл өнчрөл, эвдрэл сүйрэл байсан билээ. XX зуун цэрэг, улс төр, экологи, ёс суртахуун зэрэг сүйрлүүдээрээ бүхэлдээ дэвшлийн үзэл санаанд бүх нийтийг хамарсан цөхрөлийн үе болж үлджээ. Фашизмаас эхлэн цэргийн эрхтний ноёрхол хүртэлх цуст диктатур, аймаглан устгах ба үй олноор нь залхаан цээрлүүлэх яргалал, атомын бөмбөгдөлт, атомын цахилгаан станцуудын эвдрэл сүйрэл, дэлхий нийтээр зон олныг атом, хими, бактерологийн зэвсгээр устгах байнгын аюул занал гэх мэт нь шударга хүн төрөлхтний ирээдүйдээ итгэх өөдрөг үзлийг олон талаар алдагдуулахад хүргэсэн юм.

Энэ мэтээр дэвшлийн биш, харин глобаль хямралын үзэл санаа XX зууны гол утга санаа болоход хүргэсэн нь эргэлзээгүй юм.

Гэвч XX зууныг дан ганц сөрөг талаас авч үзэх нь шударга ёсонд хэрхэвч нийцэхгүй. Энэ зууны эцсээр хүн төрөлхтөн социалист, капиталист хэмээх хоёр системд хуваагдах, халуун цөмийн зэвсгээр бие биесээсээ түрүүлэх, хүйтэн дайны хэнээрхэлээр хордохоо больсон билээ. Ингэснээр Дэлхийн тив, бүс нутаг, улс орон, аль ч өнцөг булан бүрт амьдарч буй хүн ам арьс өнгө, нас хүйс, эд хогшил, боловсрол, шашин шүтлэг, итгэл үнэмшлийн ялгааг харгалзахгүйгээр эх дэлхий дээрээ эв найрамдалтай аж төрөх, хамтран ажиллах, харилцан туслалцах, суралцах цоо шинэ үе эхэлсэн юм. Үүнийг XX зууны түүхийн "алтан хуудас" гэж нэрлүүштэй. Шинэ үед хүн төрөлхтөн төвөөс зугтахаас төв рүүгээ тэмүүлэх, салж тусгаарлахаас ойртож нэгдэх хандлагатай болжээ. Хүчтэй, хүчин мөхөс ба их, бага буурай улс орнуудын төр засаг өөр хоорондоо үүсч илэрсэн их, бага аливаа асуудлыг уур, омгийн харгайгаар цэрэг, зэвсгийн хүчээр биш, харин ухааны сайн улс төрийн соёлын ачаар үг хэлээ ололцож, эв зүйгээр шийдвэрлэдэг болж байна. Ийм нөхцөл байдал бүрдэхэд шинжлэх ухаан-техникийн хувьсгалын ололт шийдвэрлэх үүрэг, ач холбогдолтой байсан, байх ч болно гэдгийг зориуд тэмдэглэх нь зүйтэй юм.

Дэлхийн янз бүрийн улс орнууд өөр хоорондоо ойртох, хүчин чармайлтаа нэгтгэхэд олон чухал хүчин зүйл буюу асуудал нөлөөлсөн нь тодорхой юм.

Өндөр хөгжилтэй, хүчирхэг их гүрнүүд хүн төрөлхтний хамтын нийгэмлэгийн бусад гишүүдийн талархал, дэмжлэгтэйгээр олон улсын харилцааны тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэж ирсэн, шийдвэрлэсээр ч байна. Энэ талаар НҮБ-ын үүрэг, ач холбогдлыг онцлон тэмдэглэхгүй байх аргагүй юм.

Одоо хүн төрөлхтний өмнө хамтын хүчээр л шийдвэрлэж чадах хойшлуулшгүй олон ноцтой асуудал тулгараад байгаагийн тоонд: ДОХ, зүрх судасны архаг өвчин, хөгжлийн хоцрогдлоос улбаатай үгүйрэл хоосрол, өлсгөлөн, үхэл, байгалийн экологи, тив дамжсан авилга, хар тамхины худалдаа, хамгийн аюултай нь олон улсын аллага, хядлага зэрэг орж байна.

Эдгээр глобаль асуудлууд орон зай, цаг хугацааны хувьд ялгаатай. Хэрэв үгүйрэл хоосрол, өлсгөлөнгөөр үхэж, үрэгдэх явдал Африк, Ази, Латин америкийн тодорхой орнуудаар хязгаарлагдаж байгаа бол ДОХ, зүрх судасны өвчин, байгалийн экологид хил хязгаарын зааг байхгүй. Одоо үед олон улсын аллага, хядлагатай тэмцэх нь зөвхөн олон улсын байгууллага, НАТО, хөгжилтэй, хүчирхэг орнуудын төр засаг, түүний хүчний байгууллагын хийж

гүйцэтгэвэл зохих “явцуу” ажил хэрэг биш, аль ч орны иргэдийн ариун үүрэг мөн. Энэ талаар иргэдийн дэг журам, зохион байгуулалт, сонор сэрэмж маш чухал.

Манай эцэг өвгөд “буруу эрхэлсэн хүүхэд бухын хүзүүнээс хатуу” гэж сургаж ирсэн билээ. Гэтэл техник технологи их хөгжсөн одоо үед бухын хүзүүний шириг элдэж, эд агуурс үйлдвэрлэхэд төвөггүй болжээ. Харин буруу үзэл санаагаар төөрөгдсөн хүн бууны сум, гранат, бөмбөгний тэсрэлтээс долоон дор юм байна. Олон улсын аллага хядлагын нэг аюумшиг нь түүнийг зохион байгуулагчид бурхны нэрээр хүний үзэл санааг мунхруулан төөрөгдүүлж, амь насыг нь золиосолж байгаа явдал юм.

Аль ч глобаль асуудлын онцлог нь улс төрийн шинжтэйд оршино. Улс төрийн глобализмыг шийдвэрлэхэд шинжлэх ухааны судалгаа ихээхэн ач холбогдолтой байна. Одоо энэ талаар товчхон өгүүлье.

Судлаачид улс төрийн глобализмын талаар хоёр янзын бодол санааг баримталж ирсэн байна. Тэдгээрийн нэг хэсэг тулгамдсан глобаль асуудлыг судлах нь чухал гэж үзэж байхад нөгөө хэсэг нь хүн төрөлхтний оршин ахуйн асуудлыг судлах шаардлагатай гэдэг байна. Эдгээрийн хооронд зарчмын ялгаа байхгүй. Ялгаа нь гэвэл хэсэг, бүхлийн судалгааны л асуудал юм. Глобализмын судалгааны явцад арга зүйн хэд хэдэн чиглэл тодорч ирсэн байна.

Улс төрийн глобализмын судалгааны нэгдүгээр чиглэлийн ерөнхий арга зүй харилцан холбоотой зарчимд суурилж байгаа нь:

- Нэг гаригийн хүрээн дэх бүх орнуудын байнга өсөн нэмэгдэж буй хаилцан хамаарлыг тусгагч дэлхийн хэмжээний цогцолбор асуудлуудад хандах глобаль хандлагыг ашиглах;
- Мэдээллээр муухан хангагдсан сонгогчдын өдөр тутмын хэрэгцээг засгийн газар тэр болгон мэдэрч чаддаггүй бүх асуудал, улс төрийн шийдвэр, практик арга хэмжээний удаан хугацааны үр дагаврыг тэргүүн ээлжинд авч үзэх;
- “глобаль асуудал” хэмээх нэр томъёогоор тодорхойлогддог орчин үеийн улс төр, эдийн засаг, социаль, соёл, сэтгэл зүй, техник, үйлдвэрлэлийн асуудлуудын бүх цогцолборын мөн чанарт нэвтэрч орох явдал мөн.

Сүүлийн 30 гаруй жилийн дотор янз бүрийн орны эрдэмтэд глобаль асуудлуудыг эрчимтэй судалж иржээ. Бүхэлдээ эрдэмтдийн олонхи харилцан холбоотой хэд хэдэн бүлэг асуудлуудыг улс төрийн глобализмын талаар судлах үндсэн чиглэлийг тодорхойлох болно гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Үүнд:

- тулгарсан зорилтуудыг бүх нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлэхийн тулд цэргийн эдийн засгийг шинээр баримжаалж үзэх;
- хоцрогдсон улсуудын нийгэм-эдийн засгийн хөгжилд дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- чанарын хувьд цоо шинэ нарийн төвөгтэй экологийн асуудлыг шийдвэрлэх-хүрээлэн буй орчин дахь хортой бодисын агуулгыг багасгах, озоны давхаргын нимгэрэлтийн аюул, шүлтлэг борооны аюулыг зогсоох буюу арилгах;
- уур амьсгал дулаарах хандлагыг харгалзан эрчим хүчийг хөгжүүлэх;
- эдийн засгийн тэнцвэргүй өсөлт;
- удирдлага, арга чадварын хямралыг зохицуулан жолоодох;
- дэлхийн хүн амын хоол хүнсний хангамж, усны нөөцийн байдал;
- хүн амын тооны өсөлт, нүүдлийн урсгал;
- дэлхийн геополитикийн нөхцөл байдлын өөрчлөлт орж байна.

Глобализмын судалгааны гурав дахь чиглэлд дэлхийн оршин ахуйн бүхэллэг чанарын судалгаа хамаарагдаж байна. Энэ талаар эрдэмтдийн байр суурь, хандлага төдийлөн нэгдмэл биш байгаа бөгөөд тэд нар уг асуудлыг өөр өөрийнхөөрөө авч үзэж тайлбарлаж байна.

Улс төрийн глобализмын судалгаанд өөрчлөн байгуулах-урагшлан довтлох айхавтар технологийг чиг баримжаа болгодог багаж зэвсгийн зүй зохисгүй шинж чанараас татшалзах, соёлын глобаль асуудлыг тайлбарладаг "аядуу", нэг бүрчлэн, нарийвчилсан технологийг хөгжүүлэх, хэрэглэхийг шаарддаг хандлага байна.

Улс төрийн глобализмын үнэнийг эрхэмлэх арга зүйн шинэ баримтлал глобаль асуудлуудын судалгааны шинэ арга, стилийг боловсруулахыг шаардаж байна. Түүнийг улс төрийн герменевтик гэж нэрлэж болох юм.

Улс төрийн ертөнцийн гол талууд, системүүд, үйл явцуудад харьцуулахад улс төрийн соёлын анхдагч чанарын үүсгэл үнэн бол авч үзсэн арга зүйн гол үзэл санаа юм. Чухамхүү хэм хэмжээ, уламжлал, итгэл үнэмшил, чин хүслэнгийн цогцолбор болсон улс төрийн соёл улс төрийн үйл явцууд, институтуудын хөгжлийн үнэт мөрийн хөтөлбөр, тэдгээр (институт)-ийн хөгжлийн үндсэн чиглэлийг гаргаж өгдөг юм.

Энэхүү бяцхан өгүүллийг окутан, бусад уншигчдын сурлага, танин мэдэхүйн үйлст тус нэмэр болох зорилгоор бичсэн болохоор глобализм хэмээх нэр томъёог товч тайлбарлая. Глобализм бол хэрэгжиж биелсэн бодит бололцооны илрэл болсон ертөнцийн бүх талуудын буюу салбарууд (амьгүй, амьд байгаль, хүний нийгэм, түүний окун санааны)-ын хүрээнд өөрөө өрнөж, аяндаа хэрэгждэг буюу түүнийг субъектив хүчин хэрэгжүүлдэг объектив, түгээмэл үйл явц юм. Ингэхлээр глобализмын өөрөө өрнөх, хэрэгжих хандлагыг даяаршил, субъектив хүчний үйл ажиллагаагаар өрнөх, хэрэгжих шинж чанар буюу онцлогийг даяарчилал гэж ойлгож болох юм.

Таталцал, түлхэлцэл бол объектив ертөнцийн түгээмэл хууль мөн. Энэхүү хууль байгалийн янз бүрийн салбарт өвөрмөц хэрэгждэг билээ. Жишээ нь ертөнцөд том биетүүд буюу хэсгүүд нь жижиг биетүүд болон хэсгүүдийг өөр лүүгээ татаж байхад жижиг биетүүд буюу хэсгүүд том биетээс буюу төвөөс зугтаж байна. Энэхүү эсрэг тэсрэг хүчний харилцан үйлчлэлийн тэнцвэрийн хуулиар одод, гаригууд, галактикийн системүүд, тэдгээрийн дотор манай нарны аймаг харьцангуй тэнцвэртэй оршиж иржээ.

Байгалийн даяарчилал субъектив хүчин зүйлийн нөлөөлөл, оролцоогүйгээр явагддаг байсан билээ. Гэтэл шинжлэх ухаан-техникийн дэвшил, ололтыг хүмүүс ба тэдний янз бүрийн нийтлэгүүд, нэн ялангуяа өндөр хөгжилтэй улс орнууд зүй зохисгүйгээр (алсын хараагүй, ухаалаг бусаар) ашигладаг болсоны уршгаар байгалийн объектив хуулийн хэвийн үйлчилгээ алдагдах болжээ. Үүний тодорхой жишээ бол байгалийн экологи юм. Дэлхийн бөмбөрцгийн газрын хөрс, агаар мандал, усны бохирдол, хордолт, озоны цоорхой, олон зүйл амьтан, ургамлын хорогдолт, үхэл мөхөл зэрэг нь хүн төрөлхтний ухамсартай ба ухамсаргүй даяарчилагдсан үйл ажиллагааны хор уршиг мөн.

Ийнхүү байгалийн экологи даяаршмал, даяарчилагдмал шинжтэй болж, экологийн сөрөг үзэгдэл, хор холбогдлын эсрэг тэмцэл улам бүр даяарчилагдсаар байна.

Сүүлийн жилүүдэд манай нийгмийн шинжлэх ухааны сабларын нилээд эрдэмтэн-судлаачид экологийн асуудлыг олон улсын болон улс орныхоо цар хүрээ, түвшинд судалж, туурвисан бүтээлүүддээ шинжлэх ухаан-практикийн ач холбогдолтой санал, дүгнэлт зэргийг дэвшүүлсэн байна. Тэдгээрийн дотроос Монгол улсын шинэ цагийн (1990 оноос одоо болтлох үеийн) (ажиллаж байсан, ажиллаж байгаа) хоёр Ерөнхийлөгч П.Очирбат, Н.Багабанди нар глобализмыг нухацтай судалж, хэд хэдэн дорвитой бүтээл гаргасан нь сайшаалтай.

Зохиогчид өөрсдийнхөө бүтээлд “даяаршил”, “даяарчилал”-ын шинжлэх ухааны категори, ярианы хэлний ойлголтын агуулгыг гүнзгийрүүлэн, хэлбэрийг баяжуулжээ. Ингэх нь ч зүйн хэрэг юм. Ерөнхийлөгч улсынхаа төрийн тэргүүн, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Үндэстнийхээ эв нэгдлийн бэлэгдэл, түүний аюулгүй байдлын зөвлөлийн даргын хувьд улс орныхоо олон зууны түүхийн эерэг, сөрөг уламжлал, туршлага, одоогийн байдал, хэтийн төлөвийг сайтар судлан мэдэж, үндэсний ашиг сонирхлыг олон улсынхтай харьцуулан Монгол улсын хөгжил дэвшилт, тусгаар тогтнол, аюулгүй байдлын талаар зөв дүгнэлт, арга, бодлого боловсруулах, түүний биелэлтийг зохион байгуулах, үр дүнг тодорхойлон цэгнэх бололцоотой юм. Гэвч үндэсний аюулгүй байдлыг хангах нь дан ганц Ерөнхийлөгчийн үүрэг биш ээ. Хэдхэн жилийн өмнө НҮБ томъёолон баталж, тунхагласан бөгөөд дэлхийн ихэнхи улс орон дагаж мөрдөж буй “иргэн бүр аюулгүй байдлаа хамгаалах үүрэгтэй”-тэйн ёсоор Үндэснийхээ аюулгүй байдлыг хамгаалах нь түүний шударга журмын үүрэг, ариун буяны үйлс мөн.

Эдүгээ үед хүний нийгмийн хүрээн дэх даяаршил, даяарчилал дараах чиглэл, хэлбэрээр өрнөж байна. Үүнд: Нэгдүгээрт, эдийн засгийн чиглэлээр үйлдвэрлэлийн макро, микро түвшин, худалдаа, үйлчилгээ, банк, санхүүгийн салбарыг шинээр (шаардлагатай, хэрэгцээтэй газар, улс оронд) байгуулах, хуучныг шинэчлэн төгөлдөржүүлэх, өргөтгөн тэлэх талаар хүч хавсрах, хөрөнгө оруулах, зээл тусламж олгох ба тэдгээрийг авч ашиглах талаар даяарчлал өргөн далайц, хурдтай хэрэгжиж байна. Даяаршлын энэхүү чиглэлийг хэрэгжүүлэх буюу даяарчилахад олон улсын банк, санхүүгийн байгууллага, өндөр хөгжилтэй орнууд: АНУ, Япон, БНСУ, Европын холбооны гишүүн хүчирхэг орнууд томоохон үүрэг гүйцэтгэж байна. Орон зайн ойр, хол, хөгжлийн ялгаанаас хамаарахгүйгээр дэлхийн аль ч орон зах зээлийн хуулийн үйлчилгээнд татагдан орж байгаа нь эдүгээгийн дэлхийн эдийн засгийн даяаршлын үндсэн гол хандлага, онцлог болж байна.

Энэ чиглэлийн даяаршил, даяарчлал хоцрогдсон, буурай орнуудын эдийн засгийг өөд татах, дэлхийн улсуудын эдийн засгийн хөгжлийн түвшинг яван явсаар ойртуулах, “жигдрүүлэх”, тив, бүс нутаг, хэт их хөгжилтэй орны эдийн засгийн монополчлолыг хязгаарлах, өрсөлдөөнийг сулруулах гэх мэт нь асар их ач холбогдолтой юм. Үүний зэрэгцээгээр сөрөг үр дагавар байж болохыг үгүйсгэх үндэсгүй юм. Хэрэв буурай хөгжилтэй аль ч орны эрх баригч хүчин үндэснийхээ эрх ашгийг дутуу дулимаг харгалзах буюу умартвал даяарчлалын хөлд автагдаж, үерт нь живж болзошгүй. Ер нь өндөр хөгжилтэй улс орнуудын хөнгөлөлттэй хүүтэй ба хүүгүй зээл, тусламж, буяны өглөгийн цаана тэдний тодорхой зорилго, ашиг сонирхол байгаа нь ойлгомжтой юм. Энэ бол манай улсыг гаднын амин чухал хэрэгцээ, шаардлагатай зээл, тусламж зэргээс татгалзуулах гэсэн хорон санаа хэрхэвч биш ээ. Тийм санаа гаргавал ёстой л “нуухыг нь авах гээд нүдийг нь сохлох” гэгч болно.

Хоёрдугаарт, улс төрийн харгис дэглэмийг ардчилсан дэглэмээр халах үйл хэрэг даяаршиж, даяарчлагдаж ирсэн билээ. Үүний үр дүнд тоталитаризм, авторитаризмийн биелэл болж байсан германийн фашизм, Сталины улс төрийн харгислал, социалист гэгдэж байсан олон орон дахь улс төрийн бурангуй дэглэм, Латин америк, африк, Азийн нилээд орны цэргийн харгис хэрцгий дарангуйлал (цэргийн хунт), харгис хаанчлал гэх мэт сүйрч унасан билээ. Эдгээр нь дэлхий нийтийн учир холбогдолтойгоороо даяаршмал, ардчилсан хүчнүүдийн эсэргүүцэл, тэмцлээр устсанаараа даяарчилагдмал шинжтэй юм. Энэ бүхэн нь харгислалын эсрэг ардчиллын даян дэлхийн түүхэн ач холбогдолтой томоохон ялалт байв. Гэвч харгислалын эсрэг тэмцэл төгсгөл болоогүйг ирак, Афганистанд болсон, болж буй үйл явдал гэрчилж байна. Тагнуул, дипломат, эдийн засгийн аргын тусламжтайгаар цэрэг-зэвсгийн хүчээр бусад улс орнуудад хүчээр довтолж, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс эрээ цээргүй

оролцож байгаа их гүрнүүд зонхилсон тодорхой түрэмгий хүчинд ч, хүчинд автагдсан орны хүн амд ч нааштай, цааштай зүйл ихээхэн ажиглагдаж байна. АНУ, түүний дотнын хамсаатнууд Саддамын болон Талибаны харгис дэглэмийг түлхэн унагаж, тэдгээрт ардчилсан төр засаг байгуулж, үндэсний эв нэгдлийг бэхжүүлж, хүн амыг нь эрх чөлөөтэй аж төрөх бололцоо бүрдүүлж буй нь үнэхээр буянтай үйлс юм. Гэвч хүчээр түрээ баригчид дурьдсан орнуудын эдийн засгийн ашигтай орон зайг эзлэн авч байр сууриа бэхжүүлэх, эдийн засгийн ашиг сонирхлоо хангах, хүсэл зоригоо тулган хүлээлгэхгүй гэх баталгаа илрэхгүй байна, илрэх цаг хугацаа ч болоогүй байна. Гаднын түрэмгийллийн явцад нялх балчир үрсээс өвгөд, эмгэд, санваартан хүртэлх гэм зэмгүй үй олон иргэдийн амь бие үрэгдэж, эрэмдэг зэрэмдэг болж, асар их эд хөрөнгө, соёлын хосгүй үнэт баялаг сүйрсэн, сүйрч байгаа нь харамсалтай байна.

Ирак, Афганистаны ард иргэд улс төрийн харигислал, аллага, хядлага, дарлал доромжлол зэргээс чөлөөлөгдсөндөө баярлан бахархаж, үндэснийхээ өөртөө засан тохинох ёс, эв нэгдлийг бэхжүүлэх, эдийн засгаа сэргээн босгож, хөгжүүлэх, аж амьдралаа боловсон чинээлэг болгохыг эрмэлзэж байгаа нь тун сайшаалтай хэрэг.

Эдгээр оронд сайн юманд садаа болж буй зүйл ч их байна. Хүн амын дотор үндэсний атгаг үзэл, шашны бурангуй номлолд автаж төөрөгдсөний уршгаар гадаадын (гол төлөв америкийн) энхийг сахиулагчдыг төдийгүй, нийгмийг ардчилсан ёсоор төвхнүүлэхийг хичээгүйлэн зүтгэгчдийг эсэргүүцэхээр үл барам алан хядагчдыг аялдан дагалдагчид, тэдний золиос бологсод цөөнгүй байна. Иракад АНУ, түүний дотнын холбоотон Англи болон бусад томоохон хүчирхэг орны явуулсан, явуулж буй цэрэг дайны үйл ажиллагаа лалын ертөнц дэх сөрөг үзэлтэн, хүчнүүдийг толгойгоо өндийлгөх, олон улсын аллага хядлагын сүлжээг тэлэх, үйл ажиллагаагий нь идэвхжүүлэхэд ноцтой шалтгаан, шалтаг болсон, болж байгааг тэмдэглэхэд шударга ёсыг зөрчсөн хэрэг болохгүй буй заа. Иракад цэргээ оруулагсад, тэнд байгаа гаднын цэргүүдийг хоёр ангилж үзэх шаардлагатай юм. Тодорхой дурьдсан их гүрний цэргүүд эсэргүүцэгчдийг нухчин дарах, номхотгох үүрэг гүйцэтгэж байна. Харин бусад орны олон, цөөхөн цэргүүд, тэдгээрийн дотолр Монголын хэдхэн цэрэг гаднын довтолгоон, дотоодын хорлон сүйтгэгчдийн уршгаар эвдэрч сүйрсэн үйлдвэр, үйлчилгээний газар, эмнэлэг, сургууль, зам гүүр зэргийг засаж, сэргээн босгох, энх амгалан байдлыг тогтоох, ард иргэдийн амь бие, эд хогшлыг хамгаалах зэрэг хүмүүнлэгийн ариун үүрэг гүйцэтгэж байна.

Ардчиллыг шинээр буюу сэргээн тогтоох, бэхжүүлэн хөгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах нь улс төрийн салбар дахь глобальчлалын үндсэн гол амин чухал асуудал юм. Энэ нь хүссэн ч хүсээгүй ч даян дэлхийд түгэн дэлгэрэх зүй тогтолтойгоороо даяаршилмал, тодорхой субъектууд (зөв, шударга үзэл баримтлал, хүмүүжилтэй иргэд, улс төрийн хүчнүүд, төр засаг)-ын хүчин чармайлтаар хэрэгжиж байгаагаараа даяарчиллагдмал шинж чанартай юм.

Гуравдугаарт, хүн төвтэй хөгжлийн онол хэрэгжиж байна. Үүний онцлог нь хүнийг бүхний төвд тавьж, түүнийг (эсэн мэнд өсгөж бойжуулах, сургаж хүмүүжүүлэх, мэргэшил эзэмшүүлэх, ажил хөдөлмөр эрхлүүлэх, аюулгүй орчин нөхцөлд эрүүл мэнд аж төрүүлэх зэргээр) бүх талаар хөгжүүлэх нь социал хүрээн дэх даяаршил, даяарчилалын үндсэн зорилго болж байгаад оршино.

Дөрөвдүгээрт, хүүхэд, насанд хүрэгсэд үндэсний хэлээр ном, сонин, хэвлэл уншиж ашиглах, бичих, харийн хэл сурах хүртэл, анхны радио, утсан холбооноос эхлэн радио хүлээн авагч, гар утас, компьютерийн болон интернетийн сүлжээ хүртэл хоцрогдсон орны хүн амын үсэг бичиг үл мэдэх явдлыг арилгахаас эхлэн орон орны болосролын системийн бүх шатны сургалтын агуулгыг жигдрүүлэх, хэлбэрийг баяжуулах, ололт ба туршлагыг харилцан түгээх хүртэлх өргөн хүрээтэй, нарийн төвөгтэй үй түмэн чухал

асуудал хүн төрөлхтний оюуны салбарын даяаршил, даяарчлалд хамаарагдаж байна.

Эцэст нь хэлэхэд даяаршил, даяарчилалын эерэг, сөрөг талуудыг сайтар нягтлан судалж, тэдгээрийн хоорондын зөрчлийг олон улсын хийгээд үндэстнийхээ ашиг сонирхолд нийцүүлэн үр дүнтэй шийдвэрлэх нь орон бүрийн төр засгийн ухаалаг мэргэн бодлого, оновчтой үйл ажиллагааны шалгуур мөн.